



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/К/18

Хэрлэн сум

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хууль 30.1.16, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, 61 дугаар зүйлийн 61.1.5 дахь заалт, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 5 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор аймгийн Засаг даргын нэрэмжит Боловсролын салбарын сургууль, цэцэрлэгийн шилдэг багш шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023  
оны 07 дугаар сарын 31-ны  
дугаар захирамжийн хавсралт

## **АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ШИЛДЭГ СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Ерөнхий үндэслэл:

1.1. Энэхүү журам нь “Алсын хараа-2050” бодлогыг хэрэгжүүлэх Боловсролын байгууллагуудын багш нарын ажлын бүтээмжийг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг дэмжих, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, чадамжийг хөгжүүлэх, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

1.2. Аймгийн Засаг даргын нэрэмжит шагналаар шагнуулах багш нарыг шалгаруулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Аймгийн Засаг даргын нэрэмжит шагналаар шагнуулах багш нарын шалгаруулалтад байгууллагаас нэр дэвшихдээ дараах **нийтлэг шаардлагыг** хангасан байна.

**Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт тавих нийтлэг шаардлага:**

1. Шинэ арга зүй эзэмшиж хичээл үйл ажиллагаагаа тогтмолжуулж бусдад түгээн дэлгэрүүлсэн байх

2. Хүүхэд хамгаалал, хөгжлийн талаар шинэлэг бүтээлч ажлыг хийж тогтмолжсон байх

3. Аймгийн БШУГ-аас зарлах илтгэлийн уралдаанд оролцсон байх.

4. Гүйцэтгэлийн үнэлгээгээр 1-4 р индексэд үнэлэгдсэн, өмнөх жилээс үнэлгээний хувь ахисан байх.

5. Мэргэжлийн чиглэлээр клуб дугуйлан ажиллуулах болон Хүүхдийн Оролцооны Байгууллагыг удирдан үйл ажиллагааг тогтмолжуулсан байх

6. Мэдлэг боловсролоо дээшлүүлэх сургалтад хамрагдаж сертификатад авсан байх /модуль сургалтаас илүү мэргэжлийн сургалтад суусан бол давуу тал болно/

7. Багшийн ёс зүйн зөрчил гаргаагүй байх ба эцэх эх, сурагчдын сэтгэл ханамжийн судалгаагаар 70-аас дээш үнэлгээ авсан байх

8. Medlee.mn цахим талбарт контент нийлүүлсэн байх

9. Эцэг эхчүүдэд зориулан сурган хүмүүжүүлэх хичээл, зөвлөмж, зөвлөгөө зэргийг зохион байгуулсан, иргэд олон нийтэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлж үр дүнд хүрсэн байх

10. Улс, аймаг, бүсийн тэмцээнд өөрөө болон бэлтгэсэн сурагч нь амжилттай оролцсон бол давуу тал болох

11.Мэргэжлийн Хөгжлийн Бүлгийн үйл ажиллагаанд манлайлан оролцож, суралцахууд суурилсан шинэлэг үйл ажиллагааг зохиож, үр дүнг тооцсон байх ба сайн үйл ажиллагаагаа бусдад түгээн дэлгэрүүлсэн байх

12.Сурагчидтайгаа тогтмол ажиллаж, эрсдэл зан үйлээс урьдчилан сэргийлж, эерэг зөв зан чанарыг эзэмшүүлэх чиглэлээр хийсэн ажлын тайлан, үр дүн

### **1.Цэцэрлэгийн багш нарт тавих нийтлэг шаардлага:**

1.Шинэ арга зүй эзэмшиж хичээл үйл ажиллагаагаа тогтмолжуулж бусдад түгээн дэлгэрүүлсэн байх

2.Хүүхэд хамгаалал хүүхэд хөгжлийн талаар шинэлэг бүтээлч ажлыг хийж тогтмолжсон байх

3.Аймгийн БШУГ-аас зарлах илтгэлийн уралдаанд оролцсон байх.

4.Гүйцэтгэлийн үнэлгээгээр 1-4 р индексэд үнэлэгдсэн, өмнөх оноос үнэлгээний хувь ахисан байх

5.Мэдлэг боловсролоо дээшлүүлэх сургалтад хамрагдаж сертификат авсан байх /модуль сургалтаас илүү мэргэжлийн сургалтад суусан бол давуу тал болно/

6.Багшийн ёс зүйн зөрчил гаргаагүй байх ба эцэх эх, сурагчдын сэтгэл ханамжийн судалгаагаар 70-аас дээш үнэлгээ авсан байх

7.Эцэг эхчүүдэд зориулан сурган хүмүүжүүлэх хичээл, үйл ажиллагаа, зөвлөмж, зөвлөгөө зэргийг зохион байгуулж, иргэд олон нийтэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлж үр дүнд хүрсэн байх

8.Улс, аймаг, бүсийн тэмцээнд өөрөө болон бэлтгэсэн сурагч нь амжилттай оролцсон бол давуу тал болох

9.Мэргэжлийн Хөгжлийн Бүлгийн үйл ажиллагаанд манлайлан оролцож, суралцахууд суурилсан шинэлэг үйл ажиллагааг зохиож, үр дүнг тооцсон байх.

### **2.Шалгаруулалтад ирүүлэх материал:**

1.Нэгдүгээр шатад нэр дэвшүүлсэн байгууллагын албан бичиг

2.Төрийн албан хаагчдын нэгдүгээр маягтыг бөглөж ирүүлэх

3.Хамт олны хурлын тэмдэглэл /Шалгаруулалт явуулсан тухай илтгэх хуудас/

4.Ёс зүйн салбар хороо, хэсгийн хорооны тодорхойлолт

5.Урамшуулал олгох шалгуур бүрийг хангасныг нотлох материалыг хавсаргана

6.Тухайн жилд шалгуурын дагуу хийсэн онцлох ажил, гаргасан амжилтыг нотлох тайлан, баримтууд (сэтгэл ханамжийн судалгаа, гарын үсэг)

7.Албан хаагч өөрийнхөө нэрийг дэвшүүлж болох бөгөөд энэ тохиолдолд байгууллагын даргын албан бичгийг холбогдох материалын хамт ирүүлнэ.

### **3.Шалгаруулалтыг зохион байгуулах үе шат:**

## **Нэгдүгээр шат**

**ХУГАЦАА:** Аймгийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үндсэн багшаар ажиллаж буй "Нийтлэг шаардлага"-ыг хангасан багш бүр оролцох эрхтэй бөгөөд 2023 оны 09 дугаар сарын 01-ны өдрөөс 09 дүгээр сарын 20-ны өдөр танилцуулга бүрдүүлсэн баримт, нотолгоог үндэслэн, анхан шатны шалгаруулалтыг байгууллага дотооддоо нийтлэг шаардлагыг 100 хүртэлх хувиар үнэлэн 70-н хувиас доошгүй үнэлэгдсэн багш нарыг шалгаруулж материалыг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэсд ирүүлнэ.

## **Хоёрдугаар шат**

**ХУГАЦАА:** 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 9 дугаар сарын 30-ны ажлын хэсэг, материалыг хянаж, шаардлагатай тохиолдолд сургалтын байгууллагатай холбогдож багшийн бичиг баримтыг нягтлан шалгаж, нэгдүгээр шатнаас шалгарсан багш нарын 30 хувь нь дараагийн шатанд орох эрхтэй болно.

II шатанд шалгарсан багш нар өөрийн мэргэжлийн чиглэлээр хоёроос доошгүй цагийн хэлэлцүүлэгт хичээлийг зааж бүсийн сургууль, цэцэрлэгүүддээ түгээн дэлгэрүүлж зөвлөн туслах ажлыг хийсэн байна.

## **Гуравдугаар шат**

**ХУГАЦАА:** 2023 оны 11 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дугаар сарын 30-ны хооронд оролцогч багш нарын гүйцэтгэсэн даалгаврыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг материал хүлээн авснаас хойш ажлын 7 хоногт багтаан албан хаагчдын материалыг хянан шалгаж шалгуурын дагуу эрэмбэлнэ.

1. Гуравдугаар шатанд шалгарсан багш нарын мэдээллийг 12 дугаар сарын 01-ний өдрөөс олон нийтийн сүлжээнд 5 хоногийн хугацаанд байршуулж, санал асуулга явуулж, эцэг эх, сурагчдаас google forms ашиглан сэтгэл ханамжийн судалгааг авч нэгтгэнэ.

2. Ажлын хэсгийн хурлын шийдвэр болон олон нийтийн санал асуулгын дүнг ажлын хэсэг нэгтгэн аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг даргын захирамж гарна.

## **4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:**

Аймгийн засаг даргын Тамгын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Сэлбэ сургуулийн захирал, Боловсрол шинжлэх ухаан газар, Ахмад багш нарын холбоо, багш нарын төлөөлөл, төрийн бус байгууллага, Хүүхдийн оролцооны байгууллагын төлөөлөл бүхий 5-8 хүний бүрэлдэхүүнтэй байна..

#### **5.Шагнал урамшуулал:**

Уралдааны үе шатуудад цуглуулсан оноогоор хамгийн өндөр оноо авсан ЕБС 1, СӨБ 1 багшийг орон сууц худалдан авахад нь дэмжлэг үзүүлж тус бүр 25,0 сая төгрөгөөр ЕБС 1, СӨБ 1 ,багшийг хувийн сууц барихад нь тус бүр 10 сая төгрөг, ЕБС 1 багшид 5 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг нийт 5 багшийг шагнаж урамшуулна.

#### **6. Хүлээгдэж буй үр дүн:**

- Мэргэжлийн тасралтгүй хөгжилд багшийн манлайлал хөгжсөн байна.
- Багшийн сайн туршлага, санал санаачилга, бүтээлч үйл ажиллагааг сурталчилсан байна.
- Багшийн нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

#### **7.Түгээн дэлгэрүүлэлт:**

Улс аймгийн хэмжээнд Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим сайт, Боловсрол, шинжлэх ухааны газрын пэйж хуудсаар түгээн дэлгэрүүлж, сурталчилна. Сүүлийн шатад шалгарсан 5 багшийн нэвтрүүлгийг хийж, олон нийтэд түгээнэ.

#### **8.Шагнал гардуулах: Шагналыг багш нарын баяраар гардуулна.**

**Ерөнхий зохион байгуулагч:**

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАР**

**Хамтран зохион байгуулагч:**

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУД  
ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУД**